

2016-10-21

Хламид, өвчтөний мэдээлэл (2016-10-21)

Халдвар хамгааллын эмч нарын халдвар хамгааллын хуудас.

Танд яагаад энэ мэдээллийг өгсөн бэ?

Та хламидын халдвар авсан эсвэл авсан байх магадлалтай. Энэ хуудсанд хламид, үүнийг хэрхэн эмчлэх ба та юу хийх шаардлагатай талаар мэдээлэл бий.

Хламид гэж юу вэ?

Хламид нь шээсний сүв, үтрээ ба шулуун гэдэсний салст бүрхэвчид голдуу суудаг бактери юм. Хламид заримдаа хоолойд сууж болно. Хүн хламидыг удаан тээж, заримдаа халдвар авснаа мэдэхгүй хэдэн жил ч болж болно.

Хүн яаж хламидын халдвар авдаг вэ?

Хламид юуны түрүүнд хамгаалалтгүй бэлгийн харьцаа буюу үтрээ эсвэл шулуун гэдэсний хавьталтаар, мөн заримдаа амын бэлгийн харьцаагаар дамжина. Хламид заримдаа петтинг* ба секс тоглоомоор халдаж болно.

Хламид хувцас, алчуур эсвэл жорлонгоор дамжихгүй, учир нь бактери хүний биенээс гадуур амьдрах чадваргүй. Хүн хэд хэдэн удаа хламидын халдвар авч болно.

*петтинг = “таалах”, хавьтахгүйгээр бие биеэ таалах, харилцан гар хангалга.

Хламидтай болсноо хүн мэдэх үү?

Халдвар авсан ихэнх хүмүүст шинж тэмдэг байдаггүй, өөрөөр хэлбэл хүн халдвартайгаа мэддэггүй.

Зарим хүмүүс шээх үед хорсож байгааг анзаардаг.

Эмэгтэйчүүдийн үтрээнээс цустай шингэн гарах ба / эсвэл гэдэсний доогуур хэсгээр өвдөж болно. Эрэгтэйчүүдийн шээсний сүвээс шингэн гарах ба төмсөг нь өвдөж болно. Шулуун гэдэсний хавьталт хийсэн бол тэндээс шингэн гарч болно.

Ямар нэгэн шинж тэмдэг байхгүй ч хламид маш амархан халдварлах чадвартай.

Хламид аюултай юу?

Эмчлүүлэхгүй бол эмэгтэйчүүд өндгөвчний хоолойдоо гэмтэл авч, улмаар жирэмслэхэд хэцүү болох эсвэл үр хөврөл умайн гадна тогтох (савны гадуурх жирэмслэлт) эрсдэлтэй. Эрэгтэйчүүдийн төмсөгний дайвар эрхтэн үрэвсэж болно. Хламид нүдний үрэвсэл ба заримдаа үе мөч өвдөхөд хүргэж болно.

Хламидыг хэрхэн эмчлэх вэ?

Хламидыг антибиотикоор (эм) эмчлэнэ. Та эмээ зааврын дагуу хэрэглэж, өөрт өгсөн зөвлөгөөг дагавал халдвар арилна. Эмчилгээ үнэгүй.

Та эмнэлэг дээр эргэж ирэх цаг авсан бол заавал ирэх ёстой.

Та хламидтай бол хэн нэгэн хүнд өвчин халдаах эрсдэл авч болохгүй. Эмчилгээ дуустал, өөрөөр хэлбэл 10 хоног өнгөртөл, хавьтахгүй эсвэл өөр төрлийн бэлгийн харьцаанд орохгүй байх нь баталгаатай. Та бэлгийн харьцаанд орвол, тэр хүндээ өөрийгээ хламидтайг хэлж, мөн хамгаалалт (бэлгэвч) хэрэглэх ёстой.

Халдвар мөрдөлт гэж юу вэ?

Хламидтай хүмүүсийг олж, тэднийг эмчлэх нь маш чухал, ингэснээр нэгд, гэмтэл (дээр дурдсан) авах, хоёрт, халдвар улам олон хүнд тарах эрсдэл багасах юм.

Тиймд та хламидтай бол халдвар мөрдөгчид өөрийн (заримдаа бүр сүүлийн нэг жилийн хугацаанд) хавьтсан / бэлгийн харьцаанд орсон хүн эсвэл хүмүүсийг хэн болохыг хэлэх ёстой.

2016-10-21

Таны халдвар мөрдөгчид хэлсэн зүйл нууц (нууцлал). Таны мэдээлсэн хүмүүс таныг гэж мэдэхгүй. Тэд зөвхөн өөрсдийгөө шинжилгээ өгөх ёстой гэдгийг л сонсоно.

Хламид Халдвар хамгааллын хуульд орсон байдаг - энэ юу гэсэн үг вэ?

Халдвар хамгааллын хуульд хламид мэт өвчнийг зогсоож, бусдад тараахгүйн тулд ямар мөрдөх дүрэм журам байдаг талаар бий. Хламидтай эсвэл тийм байх магадлалтай хүн өөрийн эмчийн өгсөн дараах дүрэм журмыг мөрдөх ёстой:

- Эмч танд эргэж ирэх цаг өгсөн бол заавал ирэх ёстой.
- Та өөрийн бэлгийн харьцаанд орох хүнд хламидтай эсвэл тийм байх магадлалтай тухайгаа хэлэх ёстой.
- Та эмчилгээ / шинжилгээ хийгдэж дуустал бэлгийн харьцаанд орвол хамгаалалт хэрэглэх ёстой.

Та өөрт өгсөн мөрдөх дүрэм журмыг буруу гэж үзэж байвал харьяаллын эмнэлгийн халдвар хамгааллын эмчтэй холбоо барьж болно.

Та нэмэлт мэдээлэл авахыг хүсч байна уу?

Хламидын талаарх нэмэлт мэдээллийг дараах хуудсаас уншиж болно:

www.1177.se

www.folkhalsomyndigheten.se

www.umo.se (интернет дах өсвөр үеийнхэн залуучуудын хүлээн авах эмнэлэг)

Сайн дурын мэдээллийн цонх (*frivillig informationsruta*)

Та дараах хүмүүстэй уулзсан (*Du har träffat*)

.....

Халдвар мөрдөлтийн захиалсан цаг (*Smittspårning bokad datum*)

.....

Дараагийн давтан цаг (*Nästa återbesök*)

.....

Хүлээн авах эмнэлгийн утас / утасны цаг (*Telefonnummer/telefontid till mottagningen*)

.....